

МОНГОЛЫН ГАЗАР НУТГИЙН НЭР НҮҮДЭЛЧНИЙ СОЁЛТОЙ ХОЛБОГДОХ НЬ

Ч.Батсүрэн

Нүүдэлчин аж төрөх ёс заншлаа хадгалан үлдсэн цөөхөн улс үндэстэн дэлхий дээр оршин тогтнож уг соёлоо тээсээр ХХI зуунтай золгосон байна.

Ийм улс, үндэстний нэг нь Монголчууд.

Хүн төрөлхтөний түүх нүүдэлчнээс эхтэй гэж Гегель айлджээ. Тэгэхлээр хүн төрөлхтөний түүхийн эх материалыг өнөө хүртэл хадгалж ирсэн монголчууд даяаршлын энэ их давалгаат эрин үед хэл, соёл, ёс заншил төдийгүй аж төрөх өвөрмөц арга ухаанаа хадгалсаар байгаа нь бахархал бус уу.

Нүүдэлчин монголчуудад гурван их онцлог бий гэж үзмээр байна. Үүнд **нэгдүгээрт**, Тэнгэр огторгуйтай харьцах соёл, буюу тэнгэр унших ухаан. Тэнгэр унших ухааны ачаар ойртон ирэх элдэв үзэгдэл, осол аюулаас гарз хохирол багатай гарч байсан түүх, учрал нэн олонг бид бүхэн мэдэж байна.

Тэнгэрээ хараад, нар, сар, од гараг, ертөнцийн хөдөлгөөн, байршил зэргийг ажиглаад ирэх өвөл, хавар, зун, намарт яаж аж төрөх тухайгаа төлөвлөөд бэлтгэлээ базаана. Мөн хур бороо урих, оруулах, орох бороог алсуур тойруулах, улмаар зогсоох зэрэг эрдэмд мэргэшсэн хүмүүс олон байжээ.

Энэ бол тэнгэр уншиж, тэнгэртэй ярилцах нүүдэлчин соёл, арга билиг, энэ бүгдийг зан үйл болтол нь өөрийн болгосон их эрдэм юм.

Хоёрдугаарт, уул хангай, мод, бут, өвс ургамал зэрэг байгалийн элдэв юмс үзэгдэлийг ангилан таних арга. Ингэж ангиласнаар хэзээ хаашаа нүүх, хаана ямар малд тохирох өвс ургамал элбэг байгааг олж мэдээд тэнд нутаглан суурьшихаар нүүж очно. Газар дэлхий, түүний өвс ургамалыг таних гэдэг нь мал сүргээ өсгөж үржүүлэх, ашиг шимийг нь арвижуулахтай шууд холбоотой зүйл. Мөн өөрсдийгөө, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөнийг эмчлэх, ариусгах арга ухааныг эрж хайх явцдаа өвс ургамалын эмчлэх чанарыг олж таньсан байдаг. Энэ бол газар таних, өвс ургамал мэдэх ухааны үүд юм. Энэ бүх ойлголт, зүй зохист үзэгдэл хуримталсаар газар нутгаа нэрлэх зан үйл үүссэн гэж үзвэл зохистой юм.

Гуравдугаарт, малаа таних арга, ухаан гэж бий. Мал бүхэн өөр өөр ааш зантай. Энэ бүгдийг ажиглахдаа, унаж, ачиж эдэлж хэрэглэх, сааль сүү, үс ноосыг нь авах ашиглах үедээ анзаарч ажиглаж мэднэ. Ингэж ухаарч ойлгосны дараа мал бүртэй тохируулж харьцаж унаж эдэлнэ. Унаж эдлэх гэдэгт бод мал (адуу, үхэр, тэмээ) хамаарна.

Нүүдэлчид ийнхүү тэнгэр, газар, мал гурваа шүтэлцээт холбоонд нь таних аргаар аж төрж ирсэн байх юм.

Энэ бүх шалтгаант холбооноос үүдээд газар нутгаа нэрлэх, онцлох зан үйл тодроод ирнэ. Энд зөвхөн малтай холбоот зарим үгээр газар нутаг уул, усаа нэрлэсэн онцгой гэмээр цөөхөн нэр авч үзье.

Монгол бичгийн хамгийн анхны дурсхал хэмээн одоогоор нэрлээд байгаа Чингисийн чулууны бичигт **Буха сочихой** гэх газрын нэр гарч байна. Анхны гэх энэ бичээст Буха (бух) гэх үг тааралдана. Энэ мэтээр малаараа, түүний эд эрхтэн, зан байдал, ашиг шим, ааш зан,

Ч.Батсүрэн

Хүмүүнлэгийн ухааны их сургууль
nom-ekhe@mongolian.mn

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

тоног хэрэгслээр нэрлэсэн газар, усны нэр хэдэн мянгаар тааралдаж байна.

Нүүдэлчин монголчуудын оюуны соёлын их өв – “Монголын Нууц Товчоо” хэмээх тулгар бичигт Сэлэнгийн Буур хээр [Selengge-yin Buur-a Keer-e] (152), Хар сүүл гол [Qar-a seül] (159), Хэрлэний Аргал Хөхий [Kelüren-ü ArgaL goügi] (183), Хар халзан элстэй [Qar-a qaljid eled] (170), Тэмээн хээр [Temeen keeri] (190), Улаан бухын харгуй [huLaan buq-a-yin yabursan mög-dür] (240) зэрэг малтай холбоотой үгээр нэрлэсэн газрын нэрс тааралдаж байна.

Энэ бяцхан үгүүлэлд малын тухай үгээр газар нутгаа нэрлэсэн сонин содон гэж үзэж болох цөөвтөр үг сонгов.

Үнхэлзэг толгой, Үнхэлзэг ам гэх үг (Өвөрхангай) тааралдана. Үнхэлзэг гэх эрхтэн малд огт байдаггүй. Харин малынхаа махыг боловсруулж хэрэглэх тохиолдолд зүрхний гаднах зузаан бөх хальсыг тусгайлан аваад дотор нь гол мах чихээд хүүхэд багачууд хувь болгож өгөхөөр үнхэлзэг буй болгож хэрэглэдэг. Уул хальс нэгэнт зүрхний хамгаалалт бүрхүүл учраас зүрхэн хэлбэртэй. Гэвч зүрхээс арай мөлгөрдүү хэлбэртэй. Үнхэлзэг гэх газрын нэр ч мөн тийм хэлбэртэй байх нь зүй. Монголын газар нутгийн нэр судлалын нийгэмлэгийн бүртгэлд Үнхэлзэг нэртэй газар нэлээд бий. Харин Зүрх гэсэн нэр маш элбэг тохионо. Тэгэхлээр Үнхэлзэг нь Зүрхнээс цөөвтөр тааралдаж байна гэсэн үг. Улаанбаатар хотын нэг дүүргийг Баянзүрх гэдэг Баянзүрх хайрханаар ийн нэрлэжээ. Зүрхэн хэлбэртэй ийм уул монгол нутагт элбэг.

Дөрөө. Монголчууд бод малаа уналгад хэрэглэх үед дөрөөтэй эмээл тохош хэрэглэдэг. Уналга, эдэлгээнд адууг зонхилж хэрэглэдэг учраас дөрөө голдуу адууны эмээл хэрэглэлд холбогдоно. Иймээс дөрөөтэй холбогдох газрын нэрс ч адууны эмээлийн дөрөөний тухай ойлголт гэж болно.

Энд Дөрөө хангинах гэх газар Хөвсгөл аймагт хэд хэд тааралдана. Цавчим их уулаар хэжин явах газрын нэр. Ийм замаар явахад дээд талын дөрөө хаданд шүргэж дуугарна. Хаданд шүргээд зогсохгүй, тээглэх ч тохиол гарна. Үүнээс үүдэн Дөрөө хангинах гэх газрын нэр үүсчээ. Зарим нутагт Дөрөө хавирах (Өвөрхангай) гэх газар бий. Хангинах, хавирах хоёр энэ тухайд ойролцоо утгат үгэнд орно.

Үүнээс гадна Гүү, Гүүт, Үнээ, Үнээт, Ингэ, Ингэт, Ухна, Ухнат, Хуц, Хуцат, Буур, Буурт, Азарга, Азаргат, Хөгнөт, Шилбүүр, Шат, Хом, Уурга, Хазаар, Тохом, Аргал, Сааль, Гиваан, Шанх, Аянч, Шузгат гэх зэрэг малын нас хүйс, ашиг шим, бие эрхтэн, тоног хэрэгслэлээр нэрлэсэн уул толгод, булаг шанд, тал хөндий, гол мөрөн арвин тохиолдож байна.

Азарга, Гүү мэт ерийн байнга тааралддаг өдөр бүрийн амны уншлага болсон мэт үгс элбэг байна. Бас Гиваан, Шанх зэрэг ховордуу хэрэглээний үг Хом, Шат зэрэг зарим нутаг оронд мартагдах хандлагатай нэр ч байх юм.

Нүүдэлчдийн хэрэглээ, соёл, ёс заншил зэрэг олон ухагдахуун ойлголт газар нутгийн нэрэнд байна. Хотжих үйл явц эрчимжиж, малчид төв суурин газар бараадах нь элбэгшихийн хэрээр тэр нутаг орон эзгүйрч, олон үед хэрэглэж ирсэн нэр өөрчлөгдөх, мартагдах хандлага гарсаар байна.

Үүнийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот суурин аймаг сум, суурин газрын орших нутгийн газрын нэр бэлээхэн гэрчилж байна. Жишээлбэл Улаанбаатараас хойшоо Санзай хүртэл маш олон гуу, жалга, зураа, уул, толгой, гүвээ байдаг. Эд бүгдийг тоочин нэрлэж мэдэх хүн ховор болсон байна. Энэ мэт монгол нутгийн газрын нэр ядуурч байгааг анхаарч, судалж, бичиж үлдээх ажилд шамдах нь чухал юм. Манай залуу судлаач нар ч энэ талаар болгоож байгаа гэдэгт итгэж байна.

Бидний хийсэн олон жилийн ажиглалтаас үзэхэд газар, нутгийн нэр, мал аж ахуйтай илүү ойр холбогддог нь нотлогдож байна. Манай үхэр, адуу, хонь, ямаа тэнд байна. Тийшээ явлаа. Тэнд тэдний үхэр байна. Тэнд зүс танихгүй адуу байна гэх зэргээр мал сүргийн хөдөлгөөн, хариулга маллагаа, байршил зэргийн тухай ярих бүрийд заавал газар нутаг, ус, мөрнөө зааж нэрлэдэг. Ингэхээс ч өөр арга байхгүй юм.

SUMMARY

Mongolia is one of the few nations who had kept nomadic traditions into the XXI century. The author points out following specifics due to nomadic way of life:

Firstly, their culture and strong spiritual connections to interact with the sky and channel i.e. these transcendental energies into space.

Secondly, to apply their rich imagination and creative thinking skills to conceptualize natural objects and phenomena as trees, bushes, and plants and their classifications.

Thirdly, to use stocks to aid the description of places.

In the paper, we have explored a handful, but special places names related to stocks. They are Буха сочихой, Үнхэлзэг толгой, Үнхэлзэг ам and so on.

We, Mongolians, also have numerous structures such as: saddles, cushions, bridles, pedals used for mounting and these words are also used for naming places, for example: Хөгнөт, Шилбүүр, Шат, Хом, Уурга, Хазаар, Тохом, Аргал, Сааль, Гиваан, Шанх, Аянч, Шүзгат.

As we observed, our place names are predominantly related to the animal husbandry.